



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№22 /466/

2023.01.31

Цаг үе, үйл явдал

## ГАДААДАД ЦЭРГИЙН АКАДЕМИ, КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛНО



“Залуу офицеруудын манлайллын жил”-тэй холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалт бэлтгэлийн газраас 2 дугаар сарын 9-ний өдөр гадаадад цэргийн академи, команд штабын сургууль төгссөн бүрэлдэхүүний чуулга уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөжээ.

Энэ нь гадаад орны Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоо, хөгжлийн чиг хандлагыг Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн бодлоготой уялдуулах, гадаадад цэргийн академи, команд штабын сургууль төгсөгчдийн мэдлэг, туршлага, дадлагыг хөгжүүлэх, дэмжих, манлайллын клубуудаар дамжуулан гаргасан санал санаачилгыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход чиглэжээ.

Чуулга уулзалтад ОХУ, АНУ, БНСУ, ХБНГУ, БНФУ, БНЭУ, БНТУ, Их Британи, Япон улсад цэргийн академи, команд штабын сургууль, Дайны коллеж болон Жанжин штабын академи төгссөн бүрэлдэхүүний төлөөлөл оролцоно. Уулзалт хоёр үе шат шаттайгаар зохион байгуулагдах ба эхний арга хэмжээ нь ирэх сард болох юм.

Ахмад Д.БОЛОР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-32

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,496	3,500
EUR	3,815	3,825
CNY	517	519
RUB	48.50	49
JPY	27.15	27.25
KRW	2.84	2.86

ЗУРХАЙ



2023.01.31 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 10

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал: Эрч хүч ихэснэ Наран ургах, шингэх: 08.22-17.49 Барилдлага: Түлэх Шүтэн барилдлага: САНСАР

## "АЛДАР"-Т ӨНГӨРҮҮЛСЭН НЭГ ӨДӨР



2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр БХЯ-ны Ахмадын хорооны Улс төр, соёлын ажилтны салбар зөвлөл, "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл" төрийн бус байгууллага хамтран спорт, урлагийн өдөрлөгийг БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны А байранд зохион байгууллаа.

Энэ үеэр улс төрийн ахмад ажилтнууд "Алдар" спорт хорооны үйл ажиллагаа, Алдрын танхим, бэлтгэлийн заалуудтай танилцан цэргийн үе үеийн тамирчдын домог болсон амжилтын тухай сонирхолтой яриаг өрнүүлсэн юм.

Дараа нь спортын их танхимд хуран цуглаж үлээвэр

хөгжмийн дайчин цоглог аялгуун дор 2023 онд төрийн өндөр цол Гавьяатын эрхэм алдрыг хүртсэн мэргэжил нэгт нөхдөө алдаршуулж, хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаа явагдав.

"Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл" төрийн бус байгууллагын тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа ТББ-ын Хүндэт дэвтэрт бичигдсэн гэрчилгээ, дурсгалын зүйлийг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн хурандаа Г.Золзаяа, Монгол Улсын Үйлчилгээний гавьяат ажилтан бэлтгэл хурандаа Ч.Цог, Монгол Улсын гавьяат барилгачин бэлтгэл хурандаа Ж.Батсайхан нарт гардуулж баяр хүргэлээ.

Мөн энэхүү өдөрлөгийн үеэр үе үеийн төгсөлтийнхөн эгнээнээсээ төрсөн спортын алдартан тамирчдаа сурталчилж, хүндэтгэл үзүүлэв. Тухайлбал, 1976 оныхон Цэргийн гурван төрөлтийн тамирчин Д.Батчулуунд, 1977 оныхон хөнгөн атлетикийн мастер Б.Цэен-Ойдовт, ширээний теннисний 1 дүгээр зэрэгтэй М.Басан, хөнгөн атлетикийн тамирчин Д.Тунгалаг нарт, 1981 оныхон хөнгөн атлетикийн спортын мастер Л.Даваасүрэнд, 1982 оныхон Үндэсний бөхийн их гарын даа Ё.Амарбаясгаланд, 1983 оныхон Шатрын спортын зэрэгтэй тамирчин Л.Ганхуягт, 1988 оныхон Волейболын спортын мастер, хурандаа Д.Ганзоригт, 1992 оныхон буудлагын спортын мастер, бэлтгэл дэд хурандаа С.Мөнхбаярт, Минскийн Цэргийн улс төрийн дээд сургуулийн төгсөгчид өөрийн сургуулийн анхны төгсөгч,

ЗХУ-ын Цанын спортын дэд мастер, бэлтгэл ахмад С.Жаргалсайхан нарыг алдаршуулж хүндэтгэл үзүүлсэн юм.

Дашрамд тэмдэглэхэд, "Алдар" нийгэмлэгийн Биеийн тамирын ротын улс төрийн орлогчоор ажиллаж байсан, бэлтгэл ахмад С.Жаргалсайханыг "Алдар" спорт хорооны 70 жилийн ойн медалиар, бэлтгэл хурандаа Э.Мөнхчулууныг "Львов"-ын Цэргийн улс төрийн дээд сургуулийн 80 жилийн ойн дурсгалын медалиар шагнасныг гардуулав.

Ийнхүү спортоор амьсгалсан нэгэн өдрийг Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын авьяаслаг уран бүтээлчид ая дуу, жавхаа төгс бүжгээр түрлэг нэмсэн юм.

Энэхүү цэргийн улс төрийн ажилтнуудын 2023 оны гарааны тэмцээн волейбол, ширээний теннис, дартсны төрлөөр явагдлаа.



## "АРХИГҮЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЦГЭЭ"



Зэвсэгт хүчний 325 ангийн хорооны командын байрын бие бүрэлдэхүүн хорт муу зуршлаас татгалзах, бусдадаа зөв үлгэр дуурайллыг үзүүлэх зорилгоор "Архигүй орчныг бүрдүүлцгээ" сэдэвт нөлөөллийн аяныг гурван сарын хугацаанд амжилттай зохион байгуулжээ.

Зохион байгуулагчдын зүгээс аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг ангийн нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлснийг онцлоод дараагийн алба болох материал хангалтын албанд уг аяны хоёрдугаар үе шатыг зохион байгуулах эрхийг шилжүүлэн өгчээ.

Мөн энэ үеэр эл арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцсон цэргийн алба хаагчдыг шагнаж урамшуулсан байна.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 675,033,152

Эдгэрсэн

Нийт: 647,411,530

Нас барсан

Нийт: 6,760,921

## ХАМТАРСАН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 325 дугаар анги, баруун бүсийн Хилийн цэргийн анги салбаруудтай хамтарсан команд штабын сургуулийг энэ сарын 24-25-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Хамтарсан команд штабын сургуульд Зэвсэгт хүчний 325 дугаар анги, харьяа тусгай ротууд, баруун бүсийн хилийн анги салбарын бие бүрэлдэхүүн онцгой ач холбогдол өгч, харилцан туршлага солилцон идэвхтэй оролцсон бөгөөд хамтарсан сургуулиас гарсан санал, дүгнэлтийг тус тусын командлагч нарт танилцуулан шийдвэрлүүлэхээр болсон байна.



## "УЛИАСТАЙ 2023" ЦАСНЫ БАЯРЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Энэ сарын 29-ний өдөр Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Завхан аймгийн Улиастай сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар хамтран иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар Монгол үндэсний хувцас, өв соёлоо сурталчлах зорилготой "Улиастай 2023" цасны баярыг зохион байгууллаа.

Тусарга хэмжээний хүрээнд уулын оргил булаалдах, орс таталт, цасны хөл бөмбөг, буухиа,

флаш моб, нийтийн цэнгээнт бүжиг, хос морьтон шалгаруулах зэрэг тэмцээн, уралдааныг зохион байгуулж ард иргэд цэвэр агаарт нэгэн өдрийг баяр хөөр дүүрэн өнгөрүүлсэн юм

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 325 дугаар ангиас цасны баярт оролцсон байгууллагуудын дунд шарсан гахайн тооройн дуудлага худалдаа зохион явуулж олсон орлогоо зорилтот бүлгийн нэг гэр бүлд хандивлалаа.

**Б.ХАТАНБААТАР**



## НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт Зэвсэгт хүчний 013 дугаар анги 2023 оны 01 дүгээр сарын 26-ний өдөр Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй хамтран "Бид нэг дэлхийн хүмүүс" сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа. Энэ өдрийг тус байгууллагын дөрвөн багш 20 гаруй хүүхэд болон эцэг эхийн төлөөлөл ангийн үйл ажиллагаатай танилцан, цэрэг хүний нэг өдрийн амьдралыг биеэрээ мэдэрч, сонирхолтойгоор өнгөрөөлөө.

Энэхүү үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн Зэвсгийн албаны бие бүрэлдэхүүн тусгай тоноглолтой хувцас, буудлагын зэвсэглэлийн үзэсгэлэн гаргаж бидний ажилд дэмжлэг үзүүлсэн бол ангийн Шуурхай бүлгийн холбооны хоёрдугаар зангилгааны хамт олон урлагын хэсэгчилсэн тоглолтыг бэлтгэн сонирхуулсан юм.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн сэтгэл зүйч мэргэжилтэн Ч.Ган-Эрдэнэ ангийн нийт бие бүрэлдэхүүнд байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулж, Эерэг хандлага, байгууллагын сэтгэл зүй EQ сэдвээр яриа таниулга хөгжөөнт тоглоом төрөл бүрийн сорил авч дүгнэлт гарган хамтран ажиллаа.

**Хошууч З.АНХБАЯР**

## КОМАНДЛАЛЫНХАН ГЭР БҮЛИЙН ХАМТ ЭХ ТҮҮХИЙН ЖИМЭЭР АЯЛАВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн энэ сарын 27-ны өдөр "Чингис хаан" музейд гэр бүл, үр хүүхдүүдийн хамт зочилж, эх түүхийн жимээр аялав.

Энэ нь алба хаагчид болон тэдний гэр бүлд түүх, соёл уламжлалыг сурталчлах, нөхөрсөг дулаан уур амьсгалыг бэхжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн ээлжит арга хэмжээ юм.

"Чингис хаан" музейн тайлбарыг монгол бичиг, кирилл үсгээр хослуулсан бөгөөд анх



удаа лазер гэрэл ашиглан бичсэн гэдгээрээ онцлог байв.

Тайлбарын доод хэсэгт байрлах QR код уншуулснаар гадаад таван хэл дээр тайлбарыг уншиж, сонсох боломжтой ажээ. Хүн төрөлхтний түүх дурсгалын ховор нандин олдворууд, тэр дундаа дэлхийг байлдан дагуулж байсан Чингис хааны үеийн хосгүй үнэт үзмэрүүдийг орчин үеийн шийдэл бүхий техник технологийн тусламжтайгаар үзэх боломжийг хүн бүрт олгожээ.